


Гадаад Харилцагчдынхаа Анхааралд

Банкны харилцах данс нээлгэхэд дараах бичиг баримт зайлшгүй шаардлагатайг анхаарна уу. Шинкин банкинд данс нээлгэхээр ирэхдээ дурдсан зүйлсийг биедээ авч очоорой.

《 Банкны данс нээлгэхэд шаардлагатай бичиг баримтууд 》

Биеийн байцаалт

Оршин суух үнэмлэх (Загвар)




Эх сурвалж: Японы Цагаачлалын Товчоо Цахим хуудас

- Биеийн байцаалт нь эзэмшигчийн фото зураг, эзэмшигчийн нэр, (Япон улс дахь) Хаяг болон төрсөн огноог зайлшгүй харуулсан байна.

- Жишээ нь:
- ▶ Оршин суух үнэмлэх
 - ▶ Байнгын оршин суугчийн тусгай гэрчилгээ
 - ▶ Хувийн дугаарын карт
 - ▶ Паспорт

* Данс нээх явцад хүсэлт гаргагчийн Японд оршин суух хугацааг баталгаажуулж шалгах магадлалтай. Хүсэлт гаргагчаас нэгээс илүү биеийн байцаалт үзүүлэхийг шаардаж магадгүй.

Дардас тамга



- Данс нээх үед, өргөдлийн маягт нь хүсэлт гаргагчийн дардас тамгаар хүчин төгөлдөр болно. Ихэнх санхүүгийн байгууллага гарын үсгийг хоёрдогч сонголт болгон зөвшөөрдөг болохыг анхаарна уу.
- Та дардсаа захиалах үедээ, банкны гүйлгээний шаардлагыг хангасан байх ёстойг дэлгүүрийнхэнд сануулаарай.

Бусад шаардлагууд

- Банкны данс нээлгэхээр хандахдаа, ажлын үнэмлэх эсвэл хүсэлт гаргагчийн ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлох өөр бичиг баримт авч ирнэ үү.
- Данс нээх явцад хүсэлт гаргагчийн ажил эрхэлдэг газар луу утсаар холбогдож баталгаажуулах магадлалтайг анхаарна уу.
- Япон хэлний тусламж шаардлагатай хүсэлт гаргагч нь өөрийн ажлын хүрээллийн зэрэг өөр хүнээс туслалцаа хүсэх хэрэгтэй.
- Оюутан бол оюутны үнэмлэхээ авч очих шаардлагатай.
- Хууль тогтоомжид заасны дагуу банк, хүсэлт гаргагчийн оршин суугаа улсыг татварын зорилгоор шалгаж, мөн хүсэлт гаргагчид АНУ-ын албан татвар ногдуулах эсэхийг шалгаж болох бөгөөд хүсэлт гаргагчийн татвар төлөгчийн дугаарыг шаардаж болно.

* Түүнчлэн санхүүгийн байгууллага тус бүрийн тогтоосон дүрэм журмыг сахин мөрдөнө үү.

Цалингийн дансаа тохируулах болон ашиглалтын зардлыг автоматаар төлөх тухай мэдээллийг лавлана уу.

Харилцах дансыг худалдах эсвэл худалдан авах нь ял шийтгэл хүлээхүйц хэрэг зөрчил юм!

- Харилцах данс худалдах эсвэл худалдан авах (жишээ нь: харилцах дансны тооцооны дэвтэр эсвэл АТМ-ээс мөнгө авдаг бэлэн мөнгөний карт зарах эсвэл авах) нь Япон улсын хуулиар хориотой бөгөөд худалдагч болон худалдан авагч хоёул шийтгэл хүлээнэ.
- Хэрвээ та оршин суух хугацаа дууссан гэх мэт шалтгаанаар эх орон руугаа буцахаар болсон бол банкны дансыг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх үүднээс дансаа хаалгаарай.



Шинкин Банкуудын (Shinkin Banks) Үйлчлүүлэгчдэд “Үйлчлүүлэгчдийн Мэдээллийг” тогтмол шалгах тухай ба хамтран ажиллах хүсэлт

-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд туслана уу-

Сүүлийн жилүүдэд олон улсын нийгэмд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын ач холбогдол эрс өсч байна. Гэмт хэрэгтнүүд банкны дансыг урвуулан ашигласан өвөрмөц залилан үйлдэх гэх мэт санхүүгийн гэмт хэрэг Японд өсөх хандлагатай байна.

Санхүүгийн байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдэд найдвартай, аюулгүй орчинд гүйлгээ хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор, гэмт хэргээс үүдэлтэй орлого шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль, санхүүгийн үйлчилгээний агентлагийн “Мөнгө угаах, санхүүжүүлэлттэй тэмцэх удирдамж”-г үндэслэн төрөл бүрийн арга хэмжээ авч байна.

Эдгээр арга хэмжээний хүрээнд, [санхүүгийн байгууллагууд тэр дундаа Шинкин Банкууд өөрсдийн тодорхойлсон аргыг ашиглан үйлчлүүлэгчдийн одоогийн мэдээллийг тогтмол шалгаж байхыг хичээдэг \(*\)](#).

(*) Санхүүгийн байгууллагууд үйлчлүүлэгчдийн гүйлгээний агуулга, төлөв байдлаас шалтгаалан одоо байгаа үйлчлүүлэгчидтай гүйлгээ хийсэн харилцагчийн мэдээлэл, гүйлгээний зорилгыг тогтмол шалгаж байх арга хэмжээ юм.

Энэ байдлаар үйлчлүүлэгч бүрийн мэдээллийг тогтмол шалгаснаар, хууль ёсыг сахисан дүр эсгэсэн гэмт хэрэгтэн, террорист байгууллагуудад банкны дансыг зүй бусаар ашиглуулахаас урьдчилан сэргийлнэ. Энэхүү арга хэмжээ нь санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд гүйлгээний аюулгүй ба эрүүл орчинг бүрдүүлэх болно.

Бид [үйлчлүүлэгчдээсээ эдгээр хүчин чармайлтыг ойлгож, Шинкин Банкаас “Үйлчлүүлэгчдийн Мэдээлэл” -г шалгахтай холбоотой хүсэлт гаргасныг хүлээн авч хамтран ажиллахыг хүсч байна.](#)

Гэмт хэрэгтнүүд үйлчлүүлэгчдийн мэдээллийг янз бүрийн аргаар олж авахыг завдсан залилан мэхлэх олон оролдлогууд сүүлийн үед бүртгэгдээд байгаа тул, хэрвээ та сэжигтэй үйлдэлтэй учирвал Шинкин банкны салбартай нэн даруй холбоо барина уу. Хамтран ажилласан танд баярлалаа.